4.3. Ус хангамж, ариутгах татуургын сүлжээний төлөвлөлт

Шинээр төлөвлөж буй хорооллын ус хангамж, ариутгах татуургын төлөвлөлтийн зургийг дараах бичиг баримтыг үндэслэн боловсруулав.

Үүнд:

- Ерөнхий төлөвлөгөө
- Усан хангамж. Гадна сүлжээ ба байгууламж БНБД 40-02-06
- Ариутгах татуурга ба гадна шугам сүлжээ байгууламж БНБД 40-01-14

Хайлааст нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний усан хангамж, ариутгах татуургын системийн шугам сүлжээний төлөвлөлт, Азийн хөгжлийн банкны төслөөр хэрэгжиж байгаа Дэнжийн 1000 дэд төвийн хүрээнд хийгдэж байгаа цэвэр бохир усны шугам сүлжээний ажилтай уялдуулан эдийн засгийн хувьд ашигтай, ашиглалтын хувьд найдвартай ажиллагаатай байхаар хийлээ.

Дамжуулах хоолойн дулаан тусгаарлалтыг “Тоног төхөөрөмж ба дамжуулах хоолойн дулаан тусгаарлалт” /БНБД 41-03-99/-ийн дагуу тооцох ба дулаан тусгаарлах материалын дулаан дамжуулалтын коэффициент нь 0.05 Вт/м °С-ээс ихгүй ба дулаан тусгаарлагчийн зузаан нь 10 мм-ээс багагүй байна.

Төлөвлөлт хийгдэж буй Чингэлтэй дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх 14,5 га талбай нь Хайлаастын усан сан руу явсан гэр хорооллын цэвэр усны цагариг шугамаас хангагдаж байна. Төвлөрсөн шугамд холбогдсон 5 ус түгээх байртай.

2020 оны байдлаар Чингэлтэй дүүргийн 12-р хороонд 3495 өрхийн 14638 хүн ам оршин сууж байна. Төлөвлөлтийн хамрах хүрээнд Чингэлтэй дүүргийн 10, 11, 12, 13, 14-р хорооны нутаг дэвсгэр хамрагдсан бөгөөд урьдчилсан байдлаар 4129 өрхийн 17259 хүн ам байршиж байна.

Хайлаас орчмын хүн амын усны хэрэглээ 2020 онд авсан судалгаагаар

№	Орон сууцны хорооллын тохижилтын байдал	Хот суурины нэг оршин суугчийн унд-ахуйн хоногийн дундаж /жилийн турш/ хувийн ус хэрэглээ, л/хоног	
		БНБД 40-02-16	2020 оны хагас жилийн ус хэрэглээний судалгаа
1	Ус түгээгүүр болон ариутгах татуургатай, усанд орох онгоцгүй мөн шүршүүргүй орон сууц	100-150	60
2	Ус халаагч бүхий ус түгээгүүр болон ариутгах татуургатай, усанд орох онгоц мөн шүршүүртэй орон сууц	130-180	85
3	Ус түгээгүүр. ариутгах татуургатай халуун усны төвлөрсөн системтэй орон сууц	150-220	127
4	Ус түгээх байр, гүний худаг, тохижуулсан булгаас зөөврөөр ус авдаг орон сууц (гэр)	25-40	ЦУШ-д холбогдсон ухаалаг УТБ – 10.7 ЦУШ-д холбогдсон энгийн УТБ – 8.8 Зөөврийн УТБ – 7.8

Үүнээс төлөвлөлтийн хязгаарт буюу 14.5 га газарт 1, 5, 7-р хэсгийн 384 өрхийн 1460 хүн ам хамаарагдаж байна. Төлөвлөлтийн бүсийн хэрэглээг тооцохдоо олон нийтийн бүсэд төлөвлөсөн орон сууцны барилгын хүн амын ус хэрэглээний ачааллын 30 хувийг үйлчилгээ, олон нийтийн бүсийн барилга байгууламжид ашиглагдана гэж тооцож байна.

Унд ахуйн ус хэрэглээний зарцуулалт


Д/Д	Барилга байгууламжийн тодорхойлолт	Давхрын тоо	Барилгын тоо	Хүн ам	Өрх	Хэрэглээ л/хоног	Жигд бус коэф	Усны хэрэглээ			
								м³/хоног	м³/цаг	л/с	
1	Орон сууцны	5	8	1460	384	200	1.3	379.6	47.45	13.1	
3	Орон сууны хэрэглээ			1460	384			379.6	47.5	13.2	
4	Олон нийтийн барилга	хэрэглээний 40 %							151.8	14.2	4.0
5	Нийт хэрэглээ							531.4	61.7	17.1	

Төлөвлөж буй Хайлааст олон нийтийн төвийн усны хэрэглээ **531.4** м³/хоног бөгөөд усан хангамжийн шугам сүлжээг Хайлаастын усан сан руу явсан цэвэр усны Ф225 мм-ийн цагариг шугамаас хангагдахаар төлөвлөлөө. Төлөвлөлтийн байршилд одоо байгаа гэр хорооллын бүсийг хангаж байгаа цэвэр усны ф225 мм-ийн голчтой шугамыг 480 метр зөөж шилжүүлнэ.

Шинээр төлөвлөж буй дулааны эх үүсвэрийг ф200 мм-ийн голчтой шугамаар төвлөрсөн сүлжээнд холбоно.

Дулааны эх үүсвэрээс Дулаан хуваарилах төв болон төлөвлөлтийн барилгууд хүртэл ф80-ф100 мм-ийн голчтой шугамыг дулааны сувагт хамт суурилуулахаар тооцов.

Дулааны эх үүсвэр хүртэлх цэвэр усны шугамыг хөлдөлтийн гүнээс доор суурилуулах ба хөлдөлтийн гүнээс дээш гарсан үед халаагч кабель болон хоолойн дулаалга хийх шаардлагатай.



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТООЦОО

Д/д	Барилга байгууламжийн нэр	Хүчин чадал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	100м-ийн төсвийн жишиг үнэлгээ /сая.төг/	Хөрөнгө оруулалт /сая.төг/		
						Угсралт	Зураг төсөл	Нийт дүн
1	Ус хангамжийн шилжүүлэх шугам	Ф225мм	км	0.480	39.36	245.61	5.01	250.61
2	Ус хангамжийн ган шугам	Ф200мм	км	0.260	16.36	55.30	2.96	58.25
3	Ус хангамжийн ган шугам	Ф150 мм	км	0.410	15.58	83.04	2.96	86.00
4	Нэгдсэн дүн							394.86

Ус хангамжийн хөрөнгө оруулалтын тооцоог Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 203 дүгээр тушаалын 2-р хавсралт Гадна инженерийн шугам сүлжээ, түүний барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээний 1-р хүснэгтийн үнэлгээгээр үнийн өсөлтийн индексийг ашиглан тооцсон болно.

4.3.2 Ариутгах татуургын сүлжээ

Бохир ус гаргалгааны норм нь бохир ус зайлуулах сүлжээнд холбогдсон орон сууцны болон аж ахуй нэгжээс хоногт гаргах бохир усны дундаж хэмжээ юм. /БНБД40-01-14/-д заасны дагуу бохир ус гаргалгааны норм нь унд ахуйн ус хэрэглээний нормтой тэнцүү байна гэж тооцоолов.

Төлөвлөж буй Хайлааст олон нийтийн төвийн усны хэрэглээ 531.4 м³/хоног бөгөөд ариутгах татуургын шугам сүлжээг Дэнжийн мянга дэд төвийн инженерийн шугам сүлжээний шийдэлтэй уялдуулж төлөвлөлт хийлээ.

Төлөвлөлт хийгдэж буй нутаг дэвсгэрийн бохир усыг ф150-ф200 мм-ийн шугам шинээр татаж дэнжийн мянга дэд төвийн хүрээнд хийгдэх бохир усны ф300 мм-ийн шугамын эхний худагт нийлүүлэхээр төлөвлөлөө.

Гадаргын өндөржилтөөс хамаарч бохир усны шугамыг өөрийн урсгалаар нийлүүлэх боломжтой байна



4.4. Цахилгаан хангамжийн төлөвлөлт

Төлөвлөлтийн хамрах хүрээнд одоо байгаа 110/10/6кВ-н хүчдэлтэй 2х40МВА чадалтай “Умард” дэд станцаас “Тасган”, “Хайлааст”, “Дэнж-1000” фидерийн 10кВ-н цахилгаан дамжуулах агаарын шугамаар 10/04кВ-н хүчдэлтэй 250-400кВА чадалтай АТП-16 ком, КТПН-1 ком дэд станцуудаар дамжуулан хэрэглэгчдийг цахилгаанаар хангаж байна.

Төлөвлөлтийн талбайд 10кВ-н цахилгаан дамжуулах агаарын шугам 23км, 0.4кВ-н хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугам 40км байна.

Дэд станцуудын суурилагдсан чадал 5.8 МВА байна. Эндээс хэрэглэгчдэд холбогдсон өвлийн оргил ачаалал нь 3.1 МВА буюу 59%-ийг ашигласан үлдсэн 2.12 МВА буюу 41хувийн нөөцтэй байна.

Цахилгаан хангамжийн ачааллын тооцоо ачаалал

Төлөвлөлтийн нийт цахилгаан ачаалалыг “Орон сууц, олон нийтийн барилгын цахилгаан тоног төхөөрөмжийн төлөвлөх ба угсрах” БД 43-102-07 болон “Орон сууцны хороолол, хотхоны 6-10 кВ-ын сүлжээ болон РП, ТП-үүд” /УБЦТС ТӨХК-ийн техникийн шаардлагын тодорхойлолт: РП ТП/-ын дагуу тооцоход **6919,82 кВт** болж байна.

Төлөвлөлтийн бүсээс 500 метрийн нөлөөллийн бүсэд байгаа хэрэглэгчийн 2,2 МВА ачааллыг үлдэнэ гэж тооцвол ойролцоогоор 5 МВА гарч байна.

Д/д	Барилга байгууламжийн тодорхойлолт	Барилгын тоо	Давхрын тоо	Нэг барилгын талбай	Нийт барилгын талбай	цахилгааны ачаалал /кВт/			
						Нэгж чадал	Тооцооны чадлын коэффициент	Кзэр	Нийт
ОЛОН НИЙТИЙН БАРИЛГА									
1	Оффис	1	10	4943	4943	0.14	0.95	0.75	493.06
2	Олон нийтийн байгууллага	1	9	5158	5158	0.08	0.95	0.75	294.01
3	Спорт төв	1	3	2119	2119	0.08	0.95	0.75	120.78
4	Иргэдэд үйлчлэх төв	1	2	330	330	0.08	0.95	0.75	18.81
НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖУУД									
5	Хүүхдийн цэцэрлэг	1	2	1-313 2-960	1273	0.40	0.95	0.75	362.81
6	Хүүхдийн цэцэрлэг	1	2	1188	1188	0.40	0.95	0.75	338.58
7	Хүүхэд залуучуудын хөгжлийн төв	1	3	2220	2220	0.08	0.95	0.75	126.54
8	Цагдаагийн төв	2	4	3870	7740	0.08	0.95	0.75	441.18
9	Халуун ус, саун	1	2	1036	1036	0.30	0.95	0.75	221.45
ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА									
10	Худалдааны төв	1	4	4121	4121	0.08	0.95	0.75	234.90
11	Худалдааны төв	1	1,4	1-277 2-3680	3957	0.08	0.95	0.75	225.55
12	Жижиг дунд бизнес эрхлэгчдийг	1	4,9	4-2088 9-5346	7434	0.08	0.95	0.75	423.74

	дэмжих үйлчилгээний төв								
13	Худалдааны төв	1	2,3	2-1071 3-903	1974	0.08	0.95	0.75	112.52
14	Худалдааны төв	1	2,3	975	975	0.08	0.95	0.75	55.58
15	Худалдааны төв	1	2,4	2-1549 3-1529	3078	0.08	0.95	0.75	175.45
16	Дэлгүүр	1	3	809	809	0.08	0.95	0.75	46.11
17	Худалдааны төв	1	3	2220	2220	0.08	0.95	0.75	126.54
18	Ахуй үйлчилгээний төв	1	1,3	1-485 3-2028	2513	0.08	0.95	0.75	143.24
19	Ресторан	1	3	596	596	0.40	0.95	0.75	169.86
20	Ресторан	1	2	1859	1859	0.40	0.95	0.75	529.82
21	Зочид буудал	1	2	1090	1090	0.11	0.95	0.75	85.43
22	үйлчилгээний төв	1	2	1466	1466	0.13	0.95	0.75	135.79
23	үйлчилгээний төв	1	4	1397	1397	0.13	0.95	0.75	129.40
24	үйлчилгээний төв	2	2	1200	2400	0.13	0.95	0.75	222.30
25	үйлчилгээний төв	1	3	9168	9168	0.13	0.95	0.75	849.19
ОРОН СУУЦНЫ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ									
26	орон сууц /48айл/	8	5	2448	19584	0.06	0.95	0.75	837.22
НИЙТ									6,919.82

Дээрх ачааллыг одоогийн байдлаар Умард-110/35/10кВ, Тасган-110/35/10кВ, Хайлааст-110/35/10 кВ, Дэнжийн мянга 110/35/10 кВ-ын дэд станцуудаас холбосон бөгөөд тус станцууд хэт ачаалагдсан байгаа тул шинээр төлөвлөж буй “Хайлааст” олон нийтийн төвийг шинээр баригдсан Хүчит шонхор 110/ 35/10кВ-ын 2*40000 кВА чадалтай дэд өртөөнөөс хангахаар тооцлоо.

Хүчит Шонхор-110/35/10кВ-ын дэд өртөөний 10кВ-ын хуваарилах байгууламжийг 2 гаргалгаагаар өргөтгөн кабель шугам татаж төлөвлөлтийн талбайд 10 кВ-ын хуваарилах байгууламж барьж 2х800 кВА–ийн чадалтай 6 хаалттай дэд өртөө барьж хангахаар төлөвлөв.



Төлөвлөлтийн дагуу хийгдэх ажлын тоо хэмжээ

Дэд станцаас хуваарилах байгууламж хүртэл хийгдэх ажлын тоо хэмжээ

№	Эх үүсвэр	Эхлэл	Төгсгөл	Кабель	Трассын урт (км)
1	"Хүчит шонхор" 110/35/10 кВ-ын дэд станцад 2 ячейк	"Хүчит шонхор" 110/35/10кВ		2x10 кВ	Ком-2
2	"Хүчит шонхор" 110/35/10 кВ-ын дэд станц	"Хүчит шонхор" 110/35/10 кВ-ын дэд станц	РП.1	XLPE-10кВ	1,3
Нийт					2,2

Хуваарилах байгууламжаас хаалттай дэд өртөө хүртэл хийгдэх ажлын тоо хэмжээ

№	Эх үүсвэр	Эхлэл	Төгсгөл	Кабель	Трассын урт (км)
1	"Хүчит шонхор" 110/ 35/10 кВ-ын дэд станц	РП-1	ХТП-1	XLPE-10кВ	0,050
2	"Хүчит шонхор" 110/ 35/10 кВ-ын дэд станц	РП-1	ХТП-2	XLPE-10кВ	0,150
3	"Хүчит шонхор" 110/ 35/10 кВ-ын дэд станц	РП-1	ХТП-3	XLPE-10кВ	0,150
4	"Хүчит шонхор" 110/ 35/10 кВ-ын дэд станц	РП-1	ХТП-4	XLPE-10кВ	0,330
5	"Хүчит шонхор" 110/ 35/10 кВ-ын дэд станц	РП-1 ХТП-3	ХТП-5	XLPE-10кВ	0,140
6	"Хүчит шонхор" 110/ 35/10 кВ-ын дэд станц	РП-1 ХТП-5	ХТП-6	XLPE-10кВ	0,100
7	Нийт				0,920

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны зөвлөмж .

Монгол орон газар зүйн байршил, байгаль цаг уурын хувьд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн арвин их нөөцтэй, түүнийг үр ашигтай ашиглах байгаль цаг уурын таатай нөхцөл бүрдсэн гэж үздэг. Тухайлбал: усны, нарны, салхины, газрын гүний эрчим хүчийг ашиглах зэрэг сэргээгдэх эрчим хүчний боломжит эх үүсвэрийн нөөц байгаа гэж үзэж болно.

а. Манай улсад том, жижиг нийт 3800 гаруй гол мөрөн байдаг бөгөөд тэдгээрийн эрчим хүч үйлдвэрлэх зориулалтаар ашиглах нөөц нь 6417.7МВт буюу жилдээ 56.2 тэрбум кВт цаг цахилгаан гаргах нөөцтэй гэж үнэлэгдсэн байдаг.

б. Мөн манай орны нийт нутаг дэвсгэрт жилийн 270-300 өдөр цэлмэг байдаг, нарны гийгүүлэх хугацаа жилд дунджаар 2250-3300 цаг байна. Жилд тусах нарны цацрагийн хэмжээ нэг ам метр талбайд 1200-1600 кВт бөгөөд эрчимшил нь өдөрт 4.3-4.7 кВт цаг/ам метрээс их байна.

в. Монгол Улсын салхины эрчим хүчний нөөцийн атласт тодорхойлсноор, манай орны нутаг дэвсгэрийн 10 хувь буюу 160 мянган ам километр гаруй газарт салхины хүчийг эрчим хүч үйлдвэрлэх зориулалтаар ашиглах хангалттай нөөцтэй байна.

г. Мөн газрын гүний дулаан ашиглаж, биомасс ашиглаж дулааны эрчим хүч гарган авах арга технологиуд байгааг манай орны нөхцөлд хэдийн хэрэгжүүлж эхлээд, хэд хэдэн газарт амжилттай хэрэглэж, ашиглаж байна. Гэхдээ энэ технологийн хувьд эхний хөрөнгө оруулалтад багагүй санхүүжилт шаардагдаж буйгаас шалтгаалан одоогоор төдийлөн их биш хязгаарлагдмал цөөн тооны хэрэглээтэй байна.

Дэлхий нийтээр сэргээгдэх эрчим хүчийг ихээр ашиглах, эрчим хүчний үйлдвэрлэлд эзлэх хувийг нэмэгдүүлэхээр зорьж байгаа тул манай улсад ч энэ чиглэлээр олон тооны судалгаа, төслүүд хийгдэж, хэрэгжиж байна. Нарны эрчим хүчийг 5-р сараас 9-р сарын хооронд ашиглах бүрэн боломжтой юм.

Төлөвлөлтийн зам талбайн гэрэлтүүлгийг нарны эрчим хүч ашиглах хосолмол шийдэлтэй байх боломжтой

Цахилгаан хангамжийн хөрөнгө оруулалтын тооцоо

Д/д	Барилга байгууламжийн нэр	Хүчин чадал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	100м-ийн төсвийн жишиг үнэлгээ /сая.төг/	Инфляци	Хөрөнгө оруулалт /сая.төг/		
							Угсралт	Зураг төсөл	Нийт дүн
1	"Хүчит шонхор"110/35/10 кВ-ын дэд станцад 2 ячейк өргөтгөх	2х10кВ	ком	2.0	50.00	1.30	130.00	2.60	132.60
2	Дэд станцаас РП хүртэл 10кВ-ын ЦДКШ	XLPE-10кВ	км	5.2	9.37	1.30	633.41	12.67	646.08
3	РП-ээс ХТП хүртэл 10кВ-ын ЦДКШ	10 кВ (YJLY23)	км	1.8	9.37	1.30	224.13	4.48	228.61
4	Хуваарилах байгууламж	10кВ	Ком	1.0	780.07	1.30	1,236.00	18.60	1,254.60
6	Хаалттай дэд өртөө 2	2*800кВА	Ком	6.0	328.80	1.30	2,564.64	1.50	2,566.14
5	Нэгдсэн дүн						4,788.18	39.85	4,828.03

Цахилгаан хангамжийн хөрөнгө оруулалтын тооцооны Барилга хот байгуулалтын яамны 2020 оны БД 81-16-20 “Зураг төслийн ажлын жишиг үнэ”, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 203 дугаар тушаалаар баталсан “ Барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ хэрэглэх дүрэм” , “Гадна инженерийн шугам сүлжээ, түүний барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээ, болон Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэнгийн 2020 оны 10 дугаар сарын 06 өдрийн 62 дугаар тушаалаар баталсан “Эрчим хүчний барилга байгууламж, барих ажлын нэгж хүчин чадлын төсвийн жишиг үнэлгээний норматив” зэргийг үндэслэн тооцов.

4.5. Мэдээлэл холбооны сүлжээний төлөвлөлт

Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн 12 дугаар хороонд байрлах 13 га газар “Хайлааст” олон нийтийн төвийн бүсэд орон сууц, худалдаа үйлчилгээ, үйлчилгээний төв, оффис, цагдаа, музей, спорт, барилгын материалын төв байрууд төлөвлөсөн байна.

Тус төлөвлөлтийн бүсэд Мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны газрын 2015 оны 1/445 дугаар албан бичгийн зөвлөмжийн дагуу 19 дугаартай Үйлчилгээний төв музей, үзэсгэлэн, мини кинотетрийн барилгад мэдээлэл холбооны нэгдсэн байр төлөвлөсөн бөгөөд мэдээлэл холбооны сүлжээг нэгтгэн төвлөрүүлж, төлөвлөлтийн бүсийг мэдээлэл холбооны сүлжээний тасалдалгүй, найдвартай ажиллагааг хангах боломж бүрдэнэ.


Худаг сувагчлалын байгууламж:

Чингэлтэй дүүрэг 12 дугаар хороо “Хайлааст” олон нийтийн төвтэй хамгийн ойр худаг сувагчлал нь 7 буудлын гудамж дагуу Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ны ЭАТС-351 станцын хүрээний худаг сувагчлал байгууламж байна.


2021 онд Арбэл Алтбай ХХК- Дэнжийн 1000 дэд төвийн худаг сувагчлалын байгууламжийн 4+0 яндантай ажлын зураг төслийг хийж гүйцэтгэсэн. Тус ажлын зураг төсөлтэй уялдуулан Хайлааст олон нийтийн төвийн худаг сувагчлалын байгууламжийг цагираг сүлжээ үүсгэхээр төлөвлөв. Цагираг сүлжээний урт 1,6км болж байна.

Шинээр байгуулсан цагираг сүлжээнээс төлөвлөж буй барилгууд хүртэл 2+0 яндантай худаг сувагчлал хийхээр төлөвлөв.

Дэнжийн 1000 дэд төвийн худаг сувагчлалын төлөвлөлт



Хайлааст олон нийтийн төвийн худаг сувагчлалын төлөвлөлт



Худаг сувагчлал байхгүй хэсэгт гэрэлтүүлэг болон агаарын баганат шугамаар замбараагүй кабель шугам татдаг. Энэ нь хотын өнгө үзэмжинд сөргөөр нөлөөлдөг учир худаг сувагчлалын ажлыг хийх шаардлагатай.


Шилэн кабелийн сүлжээ

Шилэн кабелийн сүлжээний төлөвлөлтийн хувьд төрийн үйлчилгээ хүргэх зорилгоор ЭАТС-351 станцыг ашиглан шинээр 48 шөрмөстэй шилэн кабель гарган одоо байгаа сувагчлал болон шинээр хийх сувагчлалаар дамжуулан Мэдээлэл холбооны нэгдсэн байранд оруулж төгсгөлийн төхөөрөмжид холбоно. Тус байрнаас төлөвлөлтийн бүсийн барилгууд руу салбарлан шилэн кабель татаж мэдээлэл харилцаа холбооны үйлчилгээ үзүүлнэ.

Шинээр татсан шилэн кабелийн шөрмөсийг ашиглан ухаалаг системд суурилсан дохиолол хяналт удирдлагын систем бий болгох, үүрэн холбооны операторуудад түрээслэх боломж бүрдэнэ.

Шинээр төлөвлөж буй 48 шөрмөстэй шилэн кабелийн урт 5000 метр байна.

Хайлааст олон нийтийн төвийн шилэн кабелийн төлөвлөлт



Суурин телефон, өгөгдлийн холбоо, интернэтийн үйлчилгээ

Төлөвлөлтийн талбайн харилцаа холбооны хэрэглээ

Д/д	Барилга байгууламжийн тодорхойлолт	Барилгын тоо	Давхрын тоо	Өрх	Хүн ам	Хэрэглээ / интернэт, телевиз, суурин утас/
ОЛОН НИЙТИЙН БАРИЛГА						
1	Оффис	1	10	-	-	20
2	Олон нийтийн байгууллага	1	9	-	-	10
3	Спорт төв	1	3	-	-	10
4	Иргэдэд үйлчлэх төв	1	2	-	-	10
НИЙГМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖУУД						
5	Хүүхдийн цэцэрлэг	1	2	-	240	10
6	Хүүхдийн цэцэрлэг	1	2	-	480	10
7	Хүүхэд залуучуудын хөгжлийн төв	1	3	-	-	10
8	Цагдаагийн төв	2	4	-	-	10
9	Халуун ус, саун	1	2	-	-	10
ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ, ХУДАЛДАА						
10	Худалдааны төв	1	4	-	-	10
11	Худалдааны төв	1	1,4	-	-	10
12	Жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих үйлчилгээний төв	1	4,9	-	-	10

13	Худалдааны төв	1	2,3	-	-	10
14	Худалдааны төв	1	2,3	-	-	10
15	Худалдааны төв	1	2,4	-	-	10
16	Дэлгүүр	1	3	-	-	1
17	Худалдааны төв	1	3	-	-	10
18	Ахуй үйлчилгээний төв	1	1,3	-	-	10
19	Ресторан	1	3	-	-	10
20	Ресторан	1	2	-	-	10
21	Зочид буудал	1	2	-	-	10
22	үйлчилгээний төв	1	2	-	-	10
23	үйлчилгээний төв	1	4	-	-	10
24	үйлчилгээний төв	2	2	-	-	10
25	үйлчилгээний төв	1	3	-	-	10
ОРОН СУУЦНЫ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ						
26	орон сууц /48айл/	8	5	384	1536	384
НИЙТ				384	2256	635

“Хайлааст” олон нийтийн төвийн хэрэглээг бодож үзэхэд 635 болж байна. Тус хэрэглээг төлөвлөгдсөн шилэн кабелийн цагариг сүлжээг ашиглан суурь сүлжээний худаг сувагчлалын байгууламжаар хэрэглэгчийн хэрэгцээнд нийцүүлэн нэгдмэл үйлчилгээ /IP TV, суурин утас, хөдөлгөөнт холбоо, интернэт, дохиолол холбооны үйлчилгээ/ сонгон суурилуулж албан газар, айл өрхийг шилэн кабелийн өндөр хурдны сүлжээнд холбох боломжтой.

Үүрэн холбооны сүлжээ , үйлчилгээ Үүрэн холбооны оператор компаниудын бааз станцын хамрах хүрээний тархалтаас үзэхэд үүрэн холбооны бааз станц барих шаардлагагүй болно.

Шуудан холбооны үйлчилгээ Төлөвлөлтийн бүсийн төрийн үйлчилгээнд зориулж шуудан холбооны үйлчилгээний салбар шинээр төлөвлөх зайлшгүй шаардлагатай.

Хэвлэл мэдээлэл, сонин түгээх, захидал илгээмж хүргэх, өргөжүүлэхэд Шуудангийн салбарыг 7 хоногт 5 удаа авто машинаар хүлээн авч хэрэглэгчдэд 7 хоногт 1 удаа авто тээврээр түгээдэг.

Радио сүлжээ Одоогийн байдлаар тус суурьшлын бүсийн ойролцоо Радио релейний 1к станц байрлаж байгаа тул тус станцаас Монголын олон нийтийн радио болон Зарим FM станцын нэвтрүүлгийг хүлээн авах боломжтой байна.

Хөрөнгө оруулалтын тооцоо

Д/д	Барилга байгууламжийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	жишиг үнэлгээ /сая.төг/	Инфл яци	Хөрөнгө оруулалт /сая.төг/		
						Угсралт	Зураг төсөл	Нийт дүн
1	4 яндантай гол сувагчлал	м	1,600	13.11	1.30	272.69	8.70	281.39
2	Сувагчлалаар кабель суурилуулах /Шилэн кабель FO-48/	м	5,000	0.86	1.30	55.90	8.15	64.05
3	НИЙТ					328.59	6.85	345.44

6. ШААРДАГДАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТОМСГОСОН ТООЦОО

Барилгын төсөвт өртгийн тооцооллыг жишиг үнэлгээг байгалийн зарим хүчин зүйлийн нөлөөллийн болон тээврийн итгэлцүүр, 2016 оны 12 сарын 28-ний өдөр ЗГ-ын 203-р тогтоолоор баталсан “Барилгын байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг хэрэглэх дүрэм” /БД 81-106-16/-ийг баримтан тооцов.

Итгэлцүүрүүд дараах байдалтай. Үүнд:

- Төслийн байршил нь УБ хотод байрлах тул зайны итгэлцүүр өөрчлөлтгүй буюу 1 байна,
- Мөн үүнтэй адилаар байгалийн хүчин зүйлийн итгэлцүүр өөрчлөлтгүй буюу 1 байна,
- Түүнчлэн барилгын өндөрийн итгэлцүүр нь 1 метр тутамд 5%-иар өсөх болно,
- Үнийн итгэлцүүрийг Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн 74 дугаар тушаалын дагуу авсан. Үүнд Гадна инженерийн шугам сүлжээ 1.30 бусад барилга байгууламж, зам талбай дундаж итгэлцүүр 1.79 тооцов.

Тус Хөрөнгө оруулалтын томсгосон тооцоог БХБ-ын сайдын баталсан хавсралтын төсвийн жишиг үнэлгээг үндэслэн, 2021 оны үнийн индексээр тооцов. /Нийгмийн үйлчилгээний байгууллага, авто замын сүлжээ 1.23 индекс, УХАТ, мэдээлэл холбоо, дулаан хангамж индекс, орон сууцны байгууламж 1.17 индекс/. Тус барилгажилтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд ойролцоогоор нийт 216,776.02 сая төгрөг бөгөөд үүнээс эхний ээлжинд 104,587.83 сая төгрөг шаардагдах ойролцоо тооцоотой байна.

Барилгажилтын төслийг хэрэгжүүлэх санхүүжилтийг дараах эх үүсвэрүүдээс бүрдүүлэх боломжтой. Үүнд:

- Улсын болон нийслэлийн төсөв
- Төр хувийн хэвшлийн түншлэл

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа. Улсын болон орон нутгийн төсөв, Засгийн газрын сангууд, татварын орлого, татаасын бодлогоор дэмжих хүрээнд:

- Улсын болон нийслэлийн төсвөөс орон сууцны хотхон, хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл, тухайн төслийг хэрэгжүүлэх шатны авто зам, явган зам, нийгмийн дэд бүтэц, орон сууц, инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц барихад хуваарилсан хөрөнгө оруулалт
- Газрыг эдийн засгийн эргэлтэд оруулснаас бий болсон хөрөнгө



6. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТООЦОО

Үндсэн шийдлийг хэргжүүлэх явцад гадаад дотоодын хөрөнгө оруулалт, засгийн газрын бонд, хандив, тусламж, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, салбарын төслүүдийн уялдаатай, Тухайн төслүүдийг боловсруулахад тус ерөнхий төлөвлөгөө болон цаашид хийгдэх үе шатны зураг төслийн үндсэн суурь материал болгон ашиглана. Эхний ээлжинд дэд бүтцийн шугам сүлжээг барьж байгуулахаар тооцов.

Шаардагдах хөрөнгө оруулалт

№	Үзүүлэлт	Хөрөнгө оруулалтын тооцоо /Сая.төг/		Нийт	Хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн боломж	
		Эхний ээлж	Төлөвлөлт йн хугацаа		Улсын төсөв	PPP
1	Барилга, байгууламж	43820.26	102257.3	146077.56	16.7%	83.3%
	Орон сууц	29792.8	9930.93	39723.73		
2	Дулаан хангамж	11363.4		11363.4	100%	
3	УХАТ	1252.63		1252.63	100%	-
4	Цахилгаан хангамж	4828.03		4828.03	100%	-
5	Мэдээлэл холбоо	345.44		345.44	100%	-
6	Авто зам	7861,6		7861,6	100%	8.7%
7	Явган зам	3360.0		3360.0	-	100%
8	Дугуйн зам	140,6		140,6		100%
9	Инж /бэлтгэл	1823.03		1823.03	100%	
11	Нүүлгэн шилжүүлэх				100%	
	Дүн	104,587.83	112,188.23	216,776.02	60.3%	39.7%

Нийт **216,776.02** сая төгрөг шаардлагатай.

- 60.3 %-ийг улс, нийслэлийн төсөв /инженерийн дэд бүтэц, нийгмийн үйлчилгээний барилга, байгууламж/
- 39.7%-ийг хувийн хэвшил /худалдаа, тээвэр үйлчилгээ, зочид буудал гм/



Үйл ажиллагааны орлогын урьдчилсан тооцоолол

№	Орлогын төрөл	Орлого /сая төг, жилээр/	Тайлбар
Үндсэн үйл ажиллагааны орлого			
1	Үйлчилгээний төвийн үйл ажиллагаа, ресторан	2100.0	Жилийн дундаж орлого
2	Худалдаа үйлчилгээний төвүүд	6476.8	
3	Худалдааны төв	1972.8	
4	Зочид буудал, олон нийтийн үйлчилгээний байгууллага	6511.9	
	Нийт	17061.5	
Борлуулалтын орлого			
5	Оффис талбай	780.0	Эхний 2 жил борлуулна
6	Худалдаа, үйлчилгээний талбай	3450.0	
	Нийт бор-ын орлого	54280.0	

Төслийн бүтээн байгуулалт үр дүнд үйл ажиллагааны жилийн орлого 27.068 тэрбум хүртэлх орлого олох боломжтой. Үйл ажиллагааны боломжит орлогын 50-60 хувиар тооцсон.

Төслийн үйл ажиллагаа-Санхүүгийн үзүүлэлтүүдийн тооцоолол / жилээр/

№	Үзүүлэлтүүд	Тоо хэмжээ /Сая төгрөг/
1	Борлуулалтын орлого	24230.0
2	Үйл ажиллагааны орлого	27068.5
3	Борлуулалтын үйл ажиллагааны зардал	1194.27
4	Үйл ажиллагааны зардал	3924.1
5	Орлогын татварын зардал	1194.3
6	Ашиг	10748.8
	Хөрөнгө оруулалт төлөгдөх хугацаа	5-6,8 жил

Хөрөнгө оруулалтыг 8.5-10 жил хугацаанд нөхөх, цаашид тогтмол ашигтай ажиллах боломжтой байна.



Барилга байгууламжийн хөрөнгө оруулалтын тооцоо

Д/д	Бүрэлдэхүүн хэсэг	Талбайн хэмжээ м2	Нэгж төсөв	Итгэлцүүр	Нийт төсөв, сая төгрөг
1	Төрийн үйлчилгээний цогцолбор /хороо,эмнэлэг, цагдаа/	1080	1,265.55	1.79	2'446.6
2	Ахмадын өргөө	956	1,265.55		2'165.7
3	Хүүхэд залуучуудын хөгжлийн төв	1989	1,265.55		4'505.8
4	Худалдааны төв	5749	1,400.56		14'412.8
5	Үйлчилгээний төв, зочид буудал	9408	1,400.56		23'585.9
6	Худалдаа үйлчилгээ	1739	1,155.00		3'595.3
7	Ахуй үйлчилгээний төв	3359	1,228.40		7'385.9
8	Цэцэрлэг, ясли	2440	1,185.74		5'178.8
9		348	960.56		598.4
Нийт					146077.56

ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Хүчин чадал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хөрөнгө оруулалт /сая.төг/		
					Угсралт	Зураг төсөл	Нийт дүн
ИБАХ					1,752.91	70.12	1,823.03
1	Зам талбайн борооны ус зайлуулах шугам сүлжээ	Ф250-Ф300мм	км	1.62	698.35	27.93	726.28
2	Бетон хучилттай үерийн хамгаалалтын далан суваг	8X2 м	км	0.26	1,054.56	42.18	1,096.74
ДУЛААН ХАНГАМЖ					11,126.7	236,6	11,363.4
3	Дулааны эх үүсвэр өргөтгөх	5.45	Гкал/цаг	1.0	4,341.9	86.8	4,428.7
4	Гадна дулааны шугам	Ф250мм	км	0.050	209.6	4.2	213.9
5	Гадна дулааны шугам	Ф219мм	км	0.130	471.4	8.8	480.2
6	Гадна дулааны шугам	Ф159мм	км	0.255	635.7	17.2	653.0
	Гадна дулааны шугам	Ф108мм	км	0.047	63.9	4.0	67.9
7	ДХТ-1	3.3 Гкал/цаг	ком	1	508.3	27.5	535.5
8	ДХТ-2	2.7Гкал/цаг	ком	1	508.3	25.5	533.8
9	ДХТ-3 /13 дугаартай барилгын зоорийн давхарт/	0.82Гкал/цаг	ком	1	305.0	4.8	309.8
10	Гадна дулааны шугам	Ф219мм	км	0.154	558.4	6.7	656.1
11	Гадна дулааны шугам	Ф159мм	км	0.784	1,954.5	21.2	1,975.7
12	Гадна дулааны шугам	Ф125мм	км	0.112	279.2	3.0	282.2



13	Гадна дулааны шугам	Ф108мм	км	0.038	82.5	1.6	84.1
14	Гадна дулааны шугам	Ф89мм	км	0.460	972.5	19.4	991.9
15	Гадна дулааны шугам	Ф76мм	км	0.079	167.0	3.3	170.4
16	Гадна дулааны шугам	Ф57мм	км	0.060	68.4	2.5	71.0
ЦАХИЛГААН ХАНГАМЖ					4,788.18	39.85	4,828.03
17	"Хүчит шонхор"110/ 35/10 кВ-ын дэд станцад 2 ячейк өргөтгөх	2х10кВ	ком	2.0	130.00	2.60	132.60
18	Дэд станцаас РП хүртэл 10кВ-ын ЦДКШ	XLPE-10кВ	км	5.2	633.41	12.67	646.08
19	РП-ээс ХТП хүртэл 10кВ-ын ЦДКШ	10 кВ (YJLY23)	км	1.8	224.13	4.48	228.61
20	Хуваарилах байгууламж	10кВ	Ком	1.0	1,236.00	18.60	1,254.60
21	Хаалттай дэд өртөө 2	2*800кВА	Ком	6.0	2,564.64	1.50	2,566.14
УСАН ХАНГАМЖ					383.95	10.93	394.86
22	Ус хангамжийн шилжүүлэх шугам	Ф225мм	км	0.480	245.61	5.01	250.61
23	Ус хангамжийн ган шугам	Ф200мм	км	0.260	55.30	2.96	58.25
24	Ус хангамжийн ган шугам	Ф150 мм	км	0.410	83.04	2.96	86.00
АРИУТГАХ ТАТУУРГА					835.46	22.31	857.77
25	Ариутгах татуургын ширмэн шугам	Ф200мм	км	1.060	437.79	11.34	449.13
26	Ариутгах татуургын ширмэн шугам	Ф150мм	км	1.020	397.67	10.97	408.63
МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ					328.59	6.85	345.44
27	4 яндантай гол сувагчлал	4х100 мм	км	1,6	272.69	8.70	281.39
28	Сувагчлалын шилэн кабель	FO-48 core	км	5.00	397.67	10.97	408.63
НЭГДСЭН ДҮН					26,938.77	624.48	27,563.25



7. ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН НЭГДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

№	Үзүүлэлтүүд		Хэмжих нэгж	Тоо хэмжээ				
				Одоогийн байдал	Төлөвлөлийн хугацаа	Үүнээс эхний ээлж		
1	Газар нутаг		га	14.5 га				
		Зам, шугам сүлжээний газар	Га, хувь		5.0 га /34.9%/			
		Барилга байгууламжийн газар	Га, хувь		4.5 га /30,9%/			
		Нийтийн эзэмшил, бусад	Га, хувь		3.8га /26,6%/			
		Суурьшлын бүс	Га, хувь		0.7 га /5.1 %/			
	Бусад	Га, хувь		0.3 га /2.5 %/				
2	Хүн ам		хүн	-	779	1460		
3	Олон нийтийн төвийн ажиллагсад		хүн	-	413	1063		
8	Нягтрал	Барилгажилтын	Бохир	м ² /га	-	0.20/га		
			Цэвэр	м ² /га	-	1.29/га		
		Хүн амын		хүн/га	-	100 хүн/га		
9	Соёл, ахуйн үйлчилгээний барилга байгууламж	Төрийн үйлчилгээний байр		Объект	-	цогцолбор		
		Хүүхэд залуучуудын хөгжлийн төв		Объект	-	1		
		Цэцэрлэг		хүүхэд	-	200		
		Биеийн тамир, спортын заал		М ²	-	2119		
		Зочид буудал		ор	-	120		
10	Авто замын урт	Гол гудамж зам-I		км	-	2.1		
		Гол гудамж зам-II		км	-	0,89		
		Туслах гудамж зам (I,II)		км	-	0.78		
11	Бусад	Дулаан зогсоол		автомашин	-	250		
		Ногоон байгууламж		м ² /хүн	-	20-25.4		
12	Инженерийн шугам сүлжээ	Дулаан хангамж	Ачаалал		Гкал/цаг	10		
			Шугам сүлжээ	голч	мм	-	57-250	
				урт	км	-	2.05	
		ДДТ/ДХТ		тоо	-	1		
		Ус хангамж	Хэрэглээ		м ³ /хоног	-	486.1	
			Шугам сүлжээ	голч	мм	-	80-250	
				урт	км	-	1.65	
		Ариутгах татуурга	Нийт		м ³ /хоног	-		
			Шугам сүлжээ	голч	мм	-	100-350	
				урт	км	-	1.28	
		Цахилгаан хангамж	Ачаалал		мВт	-	3.5 МВА	
			Шугам сүлжээ	голч	мм	-		
урт	км			-	10.2			
Хуваарилах байгууламж			тоо	-	1			
Дэд өртөө		тоо	-	3				
13	Хөрөнгө оруулалт		тэрбум төгрөг	-	216,776.02	104,587.83		



8. ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

8.1 Хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмж

Барилгажилтын төслийг төлөвлөгөөг боловсруулахад Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөний концепц-үзэл баримтлал, Улаанбаатар хотын хойд бүсийн нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө тусгагдсаны дагуу тус “Хайлааст” олон нийтийн төвийн барилгажилтын төслийн хөгжлийн чиг хадлага, эх үүсвэр, боломжийг тодорхойллоо.

- Нүүлгэн шилжүүлэлтийг зохион байгуулж гэр хорооллыг орон сууцжуулах иргэдийг тохилог орон зайд үйлчлэх бичил бүсийг байгуулах;
- Худалдаа үйлчилгээ жижиг дунд үйлдвэрлэлийг боломжийг бүрлүүлж, хөгжүүлэх
- Худалдаа үйлчилгээ түшиглэн зочид буудал, нийтийн хоол худалдаа үйлчилгээ, бөөний төвүүд нээгдснээр шинэ ажлын байр, гарааны бизнес эрхлэх боломжийг бүрдүүлэх;
- Авто зам дагуу аялагч зорчигчдод зориулсан үйлдвэрлэл үйлчилгээ явуулах бололцоотой бичил бүсийн худалдааны хэсгийг дэмжих.
- Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн байгууламж байгуулснаар иргэдэд төрийн болон эрүүл мэндийн үйлчилгээний зохист радиус хүргэх

7.2.1. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх үе шат

Барилгажилтын төслийг хэрэгжүүлэх хугацааг хоёр үе шаттай байхаар тооцлоо.

1. Эхний үе шат 2022-2025 он /ойрын хугацааны зорилт /

Улс, орон нутгийн төсөв, гадаад орнуудын буцалтгүй зээл тусламж, хөнгөлөлттэй зээл зэрэг хөрөнгө оруулалтаар санхүүжилтын эх үүсвэрийг шийдвэрлэж эхний ээлжинд: Үүнд:

- Авто зам талбай
- Барилга байгууламж,
- Инженерийн дэд бүтэц

Олон нийтийн төвийг байгуулахад төр бодлогоор дэмжих аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг татварын бодлогоор дэмжихэд чиглүүлэх; / 5 хүртлэх жилийн татварыг хөнгөлөх/

Олон нийтийн төвийг даган бий болох худалдаа үйлчилгээний бичил бизнесийг хөгжүүлэхэд зээл, тусламжийн дэмжлэг үзүүлэх ;

Гадна талбайг тохижуулах авто зам тээврийн сүлжээг барих оршин суугчид болон үйлчлүүлэгчдэд төрөл бүрийн үйлчилгээг үзүүлэхэд дэмжлэг тусалцаа үзүүлэх.

2.Төлөвлөлтийн хугацаа 2025-2030 он

- Нийгмийн үйлчилгээний барилга байгууламж;
- Худалдаа үйлчилгээний барилга байгууламж
- Орон сууцны барилга



8.2 Хот байгуулалтын чиглэлээр эхний ээлжинд хэрэгжүүлэх, үе шат

Эхний ээлжинд нэн шаардлагатай байгаа олон нийтийн төвийн тээвэр үйлчилгээний төвийн цогцолбор болон нийгмийн үйлчилгээний барилга-байгууламж, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг тус календарчилсан төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх төслийн байршлыг салбар тус бүрээр үзүүлэв. Хэрэгжүүлэх үе шатанд төр хувийн хэвшлийг (PPP) оролцооны хэлбэрийг сонгох нь хэрэгжилтийн үр дүнг нэмэгдүүлнэ.

Хэрэгжүүлэх төслийн үйл ажиллагаа

Хүснэгт №8.2.1

№	Төслийн үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа /Эхний ээлж 2020/						Тайлбар
		2023 он	2024он	2025он	2026он	2027он	2030 он	
Төслийг эхлүүлэх								
1	Батлагдсан барилгажилтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлэх үе үйл ажиллагаа;	—						Хэрэгжүүлэх арга хэмжээний барилгажилтын үе шат зураг
2	Төслийн дагуух дэд бүтэц, эхний ээлжийн барилгуудыг иж бүрнээр барих үйл ажиллагааг эхлүүлэх	—						Төр хувийн хэвшлийн оролцоог авч үзэх
3	Төслүүдийг сонгох төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, хэрэгжүүлэх							Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын оролцоог дэмжих

Олон нийтийн төвийн барилгажилтын төслийг төлөвлөгөөний дагуу төлөвлөлтийн хэрэгжилтийг үе шаттайгаар авч үзнэ. Хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд дараах төслүүдийг хэрэгжүүлнэ. Төслүүдийн талбайн хэмжээ болон байршлаар бүсчлэлээр тодотгож, зурагт үзүүлэв.



Төлөвлөлтийн үе шат 2022-2030 он



Таних тэмдэг	Барилгажилтын үе шат	Талбай /м.кв/
	ОДОО БАЙГАА БАРИЛГА	434 м ² барилга
	2022 - 2025 он. ЭХНИЙ ЭЭЛЖ	52126 м ² барилга
	2025 - 2030 он. ТӨЛӨВЛӨЛТИЙН ЭЭЛЖ	60366 м ² барилга

“Хайлааст” Олон нийтийн төвийн төслийн хувьд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хугацаатай уялдуулан 2 үе шаттай хэрэгжихээр тооцлоо. Хэрэгжих дарааллыг сонгохдоо инженерийн нэгдсэн шугамд холбогдох эх үүсвэрийн боломж, зай хэмжээ нь эдийн засгийн хувьд хөрөнгө оруулалт бага зарцуулагдах зарчмыг баримтлав. Эхний ээлжинд нүүлгэн шилжүүлэлт хийж, инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтаар эхлүүлж орон сууц нийгмийн үйлчилгээ барилга байгууламжийг дараагийн үе шатанд хэрэгжихээр тооцлоо. Дээрх зурагт тусгагдсан үе шат нь эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан өөрчлөлт орж болно.



Төр хувийн хэвшлийн түншлэл

Хайлааст олон нийтийн төвийн цогцолбор байгуулахтай холбоотойгоор тус олон нийтийн төвийн төрийн санхүүжилтээр шийдвэрлэх дэд бүтэц гэх мэт хэсгийн бүтээн байгуулалтыг төрийн зүгээс шууд санхүүжүүлэхээс гадна хувийн хэвшилтэй хамтарч байгуулах замаар хэрэгжүүлж болох юм. Зөвхөн үйл ажиллагааны хүрээнд бус концессоор бүтээн байгуулалтыг хийх замаар үйлдвэрүүдийн өөрийн ашигт ажиллагаанаас бүтээн байгуулалтын төлбөрийг төлөх боломжтой байна.

Эрх зүйн үндэслэл

Төр хувийн хэвшлийн түншлэл (PPP) гэдэг нь төрийн агентлаг, хувийн хэвшлийн хооронд байгуулсаны үндсэн дээр хувийн хэвшлийн нэгж нь төсөлд оролцох, засгийн газрын үйлчилгээг түүний нэрийн өмнөөс гүйцэтгэх боломжоор хангагдах үйл ажиллагааг хэлнэ.

PPP-ийн үр дүнд нэг талаас төр өөрийн онцгой эрхийн хүрээнд хувийн хэвшлийг шаардлагатай нөөц бололцоогоор хангах замаар ард иргэдэд үйлчилгээ үзүүлэх буюу дэд бүтцийг бий болгох, өөрийн ачааллыг багасгах нөгөө талаас хувийн хэвшил хөрөнгө оруулалтаа оновчтой төсөлд оруулан ашигаа хүртэх боломж бүрдэх юм.

Энэхүү нарийн ээдрээтэй харилцааг эрх зүйн хүрээнд дэмжиж УИХ-аас Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийг 2009 оны 10 дугаар сарын 15-ны өдөр 64 дүгээр тогтоолоор батлан гаргасан бөгөөд уг баримт бичгийн хүрээнд "Төрийн болон орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийг концессын гэрээгээр хөрөнгө оруулагчид олгох уралдаант шалгаруулалт явуулах, концессын гэрээ, түүнийг байгуулах, өөрчлөх, дуусгавар болгох, маргаан хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилго"-той Концессын тухай хуулийг 2010 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр тус тус батлан гаргасан юм.

PPP-ийн талаар төрөөс баримтлах бодлого нь концессоо бодвол төр ба хувийн хэвшлийн хамтарч ажиллаж болох илүү өргөн хүрээг хамарч байгаа бол Концесс нь хувийн хэвшлээс хөрөнгө оруулалт хийх хүрээг илүү хамарсан байна.

Уг хуулийн дагуу Засгийн газрын 2010 оны 198 дугаар тогтоолоор “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-ыг батлан гаргаж байжээ. Харин “Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих үндэсний стратеги”-ийг Засгийн газрын 2011 оны 36 дугаар тогтоолоор баталсан байна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлогод заасны дагуу түншлэл нь дараах 5 хэлбэрээр байж болно.

- Үүнд:
- Нийгмийн салбарын түншлэл
 - Эрүүл мэнд;
 - Спорт
 - Боловсрол;
 - Соёл урлаг;
 - Шинжлэх ухаан;
 - Бусад
- Дэд бүтцийн салбарын түншлэл
 - Эрчим хүч, сэргээгдэх эрчим хүч;



- Дулаан дамжуулах болон түгээх сүлжээ;
- Мэдээлэл, харилцаа холбоо;
- Усан хангамж, ариутгах татуурга;
- Нийтийн тээвэр;
- Авто зам;
- Орон сууц;
- Бусад
- Төрийн тодорхой чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх түншлэл
- Үндэсний болон бүс нутгийн хэмжээний томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх түншлэл
- Байгаль орчны салбарын түншлэл
 - Экологи;
 - Хог хаягдлын удирдлага

Концесс

Төсвийн хөрөнгө оруулалтанд саад учирвал PPP-ын Түүнчлэн концессийн гэрээгээр гүйцэтгүүлэх боломжтой бөгөөд үүнд:

- Барилга байгууламж
- Инженерийн дэд бүтэц
- Авто зам ба гудамж замын тохижилтын хэсэг



АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- ⇒ Хот байгуулалтын тухай хууль;
- ⇒ Орон сууцны тухай хууль;
- ⇒ Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль;
- ⇒ Барилгын тухай хууль;
- ⇒ Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль;
- ⇒ Геодези, зураг зүйн тухай;
- ⇒ Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай;
- ⇒ Байгаль орчныг хамгаалах тухай хууль;
- ⇒ Хот суурин газрын ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль;
- ⇒ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль;
- ⇒ Эрчим хүчний тухай хууль;
- ⇒ Байгаль орчныг хамгаалах тухай болон бусад хууль тогтоомж;
- ⇒ Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм(БНБД 30-01-04) ;
- ⇒ Хот, суурины дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар заавар (УББ 30-201-09);
- ⇒ Барилга байгууламжийн инженер-экологийн судалгаа (БД 11-202-07) ;
- ⇒ Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, зөвшөөрөлцөх, экспертиз хийх дүрэм (ЗТБХБ-ын сайдын 2011 оны 226 дугаар тушаал) ;
- ⇒ Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм;
- ⇒ “Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг олон нийтээр хэлэлцүүлэх журам” /ЗТБХБ-ын сайдын 183 дугаар тушаал/;
- ⇒ MNS 3237: 1989 Ерөнхий төлөвлөгөө Зам тээврийн таних тэмдэг, дүрслэл;
- ⇒ MNS ISO 11091:2007 Барилгын зураг. Ландшафтын зураг боловсруулах;
- ⇒ MNS 6055:2009, Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар;
- ⇒ Бусад холбогдох норм, норматив.
- ⇒ Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл;
- ⇒ Салбарын хэмжээнд хэрэгжиж буй дотоодын болон олон улсын төсөл, хөтөлбөрүүд;
- ⇒ Азийн хөгжлийн банкны “Монгол Улсын хот байгуулалтын үнэлгээ” Жайкагийн “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн нэгдсэн судалгааг”-г ашиглах. ;
- ⇒ “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”-ын баримт бичиг;
- ⇒ Бусад төсөл хөтөлбөрүүд
- ⇒ Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030. УБ, 2016 он;
- ⇒ Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал. “Төрийн мэдээлэл” сэтгүүл, 2001. 128(215);
- ⇒ “Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр” 2009 он;
- ⇒ “Үйлдвэрлэлийг дэмжих тухай” ЗГ-ын №141 тогтоол, 2013.4.13
- ⇒ “Улаанбаатар хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөөний тодотгол, 2040 он хүртэлх хөгжлийн концепц, Улаанбаатар хотын өнөөгийн байдлын судалгаа, дүгнэлт”
- ⇒ Хайлааст нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө 2016 он;
- ⇒ Монгол Улсын бүсчилсэн хөгжил, хот байгуулалтын асуудал. УБ, 2001 он;
- ⇒ “Нийслэлийг бүс нутгийн зарчмаар хөгжүүлэх үзэл баримтлал”,
- ⇒ “УБ хотын ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын хөтөлбөрийн судалгаа”
- ⇒ Судалгааны материалууд, цахим мэдээллийн сайтууд;
- ⇒ Монгол улсын мэдээлэл харилцаа холбоо технологийн талаар 2021 он хүртэл төрөөс баримтлах бодлогын судалгаа.
- ⇒ Радио телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн баримт бичгүүд



- ⇒ Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Мэдээлэл технологи Шуудан Харилцаа Холбооны (МТШХХГ)-аас боловсруулсан Монгол Улсын мэдээлэл холбооны системийг 2020 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө
- ⇒ Мэдээлэл технологи шуудан харилцаа холбооны газраас 2015 оны 05 дугаар сарын 12-ний өдөр гаргасан зөвлөмж
- ⇒ Орон сууцны барилгын мэдээлэл, холбооны суурин сүлжээний төлөвлөлт. Ерөнхий шаардлага MNS 6580:2016
- ⇒ “Орон сууцны барилгын мэдээлэл, холбооны суурин сүлжээний суурилуулалтын ерөнхий шаардлага” MNS 6581:2016

